

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

АУДИТЫН КОД:ХОА-2022/01/НА-СТА-ТЕЗ

Цахим хуудас: www.audit.mn

Ховд хот

2023 оны 4 сарын 20

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061

Цахим хаяг: Boldbaatar khu@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Цахим хаяг: tsetsegsurena@audit.gov.mn

Утас: 70432545

Ахлах аудитор: Д.Нарантуул

Цахим хаяг: Narantuul.d@audit.gov.mn

Аудитор: Ц.Гантулга

Цахим хаяг: GantulgaTs@audit.gov.mn

Аудитор: С.Оюунжаргал

Цахим хаяг: OyunjargalS@audit.gov.mn

Аудитор: М.Энхжаргал

АГУУЛГА

1. Аудитын санал дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга
- 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
- 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
- 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
- 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан
- 4.1 Ерөнхий зүйл
- 4.2 Материаллаг байдал
- 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

АДБООУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББООУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТБОНӨХБАУХАТ	Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
ЗДТГ	Засаг даргын дамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
БОАЖЯ	Байгаль орчин аялал жуулчлалын яам
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
БИТ	Бизнес инкубатор төв

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2023.04.20 № 2/165
танай _____ -ны № _____ -т

ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
Э.БОЛОРМАА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Ховд аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Ховд аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төсвийн ерөнхийлөн захирагчийн өмнөх онуудын тайланд бүртгэлтэй Азийн хөгжлийн банкинд төлөх 926.3 сая төгрөгийн урт хугацаат өр төлбөр, 323.2 сая төгрөгийн хүү, нийт 1,251.5 сая төгрөгийн төлбөрийг бүрэн барагдуулсан байна.

Орон нутгийн төсвийн нийт зарлагыг 9.6 хувиар хэмнэсэн нь хөрөнгө оруулалтуудын ажлын гүйцэтгэл дуусаагүйгээс 2,575.0 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлээгүй, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн бараа үйлчилгээний зардлыг 1,467.7 сая төгрөгөөр хэмнэсэн нь нөлөөлжээ.

Аудитын гол асуудал

Нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 113,419.3 сая төгрөгөөр, нийт орлого 36,696.0 сая төгрөгөөр буурахад боловсрол, эрүүл мэнд, соёл, спортын байгууллагуудын төсвийг дээд шатны байгууллагуудын тайланд нэгтгэн тайлагнасан, урсгал зардлыг улсын төсвөөс шууд санхүүжүүлэх бодлогын өөрчлөлт нөлөөлсөн байна.

Бусад асуудлын хэсэг

Аймгийн ИТХ-ын 10/04 тоот тогтоолоор Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2022 оны зорилтуудын хэрэгжилт, бүтээн байгуулалтын бодлогын ажлын үр дүнг 84.85 хувийн биелэлттэй гэж үнэлжээ.

ТЕЗ-д жижиг дунд үйлдвэрлэл, бизнес эрхлэх таатай орчин бүрдүүлэх, ажлын байр бий болгох замаар ажилгүйдлийг бууруулах, 1 хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн өсөлтөөс иргэдэд хүрэх үр өгөөжийг нэмэгдүүлэхийг даалгажээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(мян.төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	33,807,026.30	35,356,401.50
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	14,783,113.50	18,842,112.50
33	АВЛАГА	9,920,678.80	9,715,813.80
34	УРЬДЧИЛГАА	1,743,772.70	3,528,927.50
35	БАРАА МАТЕРИАЛ	7,065,198.20	2,770,070.00
36	НӨӨЦИЙН БАРАА	294,263.10	499,477.70
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	220,960,339.60	105,991,040.10
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	220,960,339.60	105,991,040.10
39200	Биет хөрөнгө	206,420,257.70	96,605,922.80
39300	Биет бус хөрөнгө	14,454,284.10	9,380,117.30
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	85,797.80	5,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	254,767,365.90	141,347,441.60
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	7,128,597.10	5,217,752.10
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	6,185,253.30	5,202,752.10
41300	Өглөг	2,215,376.50	1,209,998.10
41400	Урьдчилж орсон орлого	3,969,876.80	3,992,754.00
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	943,343.80	15,000.00
42200	Урт хугацаат зээл	943,343.80	15,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	247,638,768.80	136,129,689.50
51	Засгийн газрын хувь оролцоо	247,638,768.80	136,129,689.50
51100	Засгийн газрын оруулсан капитал	80,382,459.60	32,407,922.10
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	12,495,214.90	12,318,367.60
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	1,174,288.90	9,245,693.40
51200	Хуримтлагдсан үр дүн	99,192,988.40	71,391,060.90
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	54,393,817.00	10,766,645.40
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	254,767,365.90	141,347,441.60

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(мян.төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	149,430,673.70	89,232,622.80
11	ТАТВАРЫН ОРЛОГО	14,824,127.10	28,509,693.40
110	Орлогын албан татвар	10,903,708.50	23,148,448.80
1100	Хувь хүний орлогын албан татвар	11,502,511.10	13,426,349.60
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-598,802.60	-728,584.70
1103	ААН-ын орлогын албан татвар	0	10,450,683.80
113	Хөрөнгийн албан татвар	1,699,316.20	2,041,441.20
118	Бусад татвар, төлбөр, хураамж	2,221,102.40	3,319,803.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	111,516,371.00	37,615,196.60
120	Нийтлэг татварын бус орлого	40,401,611.00	19,922,297.70
121	Хөрөнгийн орлого	3,678.10	8,067.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	71,111,081.90	17,684,831.90
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	23,090,175.60	23,107,732.80

Ховд аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	107,450,711.40	58,012,612.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	107,307,246.10	58,012,612.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	102,557,748.70	56,400,110.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	47,565,874.80	10,253,697.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,214,983.80	1,221,602.90
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,698,544.80	10,459,417.90
2104	Хангамж, бараа материалын зардал	16,366,337.20	15,461,964.40
2105	Нормативт зардал	3,043,001.90	199,351.80
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	291,713.20	188,981.20
2107	Томилот, зочны зардал	151,246.70	145,056.40
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,158,350.60	2,271,518.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,067,695.80	16,198,520.90
212	ТАТААС	566,160.70	91,434.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,183,336.70	1,521,067.40
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	143,465.30	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	41,979,962.30	31,220,010.20
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	15,096,698.40	150,047,171.10
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	26,883,263.90	-118,827,160.90

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мян.төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	222,061,022.50	84,416,824.20
11	ТАТВАРЫН ОРЛОГО	14,904,015.40	28,495,693.40
110	Орлогын албан татвар	10,903,708.50	23,134,448.80
1100	Хувь хүний орлогын албан татвар	11,502,511.10	13,412,349.60
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-598,802.60	-728,584.70
1103	ААН-ын орлогын албан татвар	-	10,450,683.80
113	Хөрөнгийн албан татвар	1,699,316.20	2,041,441.20
118	Бусад татвар, төлбөр, хураамж	2,300,990.80	3,319,803.40
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	487,443.40	498,344.30
1181	Газрын төлбөр	268,743.60	1,118,010.60
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	1,544,803.70	1,703,448.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	81,896,352.60	32,410,583.00
120	Нийтлэг татварын бус орлого	10,726,825.90	14,717,684.00
121	Хөрөнгийн орлого	58,444.70	8,067.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	71,111,081.90	17,684,831.90
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	125,260,654.40	23,510,547.90
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	186,783,600.40	42,109,137.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	186,783,600.40	42,109,137.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	80,356,981.60	38,560,151.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	48,525,595.70	11,825,616.30
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,617,899.10	1,667,098.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,142,761.50	11,139,087.60

Ховд аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2104	Хангамж, бараа материалын зардал	2,308,542.30	2,046,522.00
2105	Нормативт зардал	2,868,193.90	174,922.70
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	357,115.60	221,573.00
2107	Томилолт, зочны зардал	171,539.20	140,898.60
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,702,144.10	2,952,114.10
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,663,190.30	8,392,318.10
212	ТАТААС	566,160.70	87,684.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	105,860,458.10	3,461,302.20
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	35,277,422.10	42,307,686.60
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	30,846,099.10	36,695,767.80
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	30,846,099.10	36,695,767.80
2200	Дотоод эх үүсвэрээр	30,846,099.10	36,695,767.80
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-30,846,099.10	-36,695,767.80
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-390,444.90	-1,552,919.80
14	Бусад эх үүсвэр	117,001.00	1,040,000.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	504,445.90	2,592,919.80
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	3,000.00	-
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	4,040,878.00	4,058,999.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	10,742,235.50	14,783,113.50
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	14,783,113.50	18,842,112.50

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (мян.төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	218,262,445.00	218,262,445.00
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	937,937.90	937,937.90
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	219,200,383.00	219,200,383.00
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	208,669.00	208,669.00
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	826,871.50	826,871.50
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	519,581.50	519,581.50
9	Тайлант үеийн үр дүн	26,883,263.90	26,883,263.90
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	247,638,768.80	247,638,768.80
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	247,638,768.80	247,638,768.80
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-833,977.30	-833,977.30
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	246,804,791.60	246,804,791.60
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-9,108.20	-9,108.20
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	8,161,284.50	8,161,284.50
19	Тайлант үеийн үр дүн	-118,827,160.90	-118,827,160.90
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	136,129,689.50	136,129,689.50

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (мян.төгрөгөөр)

Ховд аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	54,609,426.30	49,371,303.53
21	УРСГАЛ ЗАРДАЛ	32,714,550.80	30,808,083.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	28,885,381.50	27,417,703.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	9,951,203.40	9,701,760.21
210101	Үндсэн цалин	6,750,548.70	6,628,947.18
210102	Нэмэгдэл	1,643,696.30	1,577,165.54
210103	Унаа хоолны хөнгөлөлт	51,648.00	51,154.98
210104	Урамшуулал	298,466.10	373,852.77
210105	Гэрээт ажлын хөлс	1,206,844.30	1,070,639.74
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,244,473.20	1,217,585.63
210201	Тэтгэврийн даатгал	847,343.60	831,702.25
210202	Тэтгэмжийн даатгал	90,542.10	88,375.59
210203	ҮОМШӨ-ний даатгал	87,173.40	83,784.48
210204	Ажилгүйдлийн даатгал	19,964.90	20,042.39
210205	Эрүүл мэндийн даатгал	199,449.20	193,680.91
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,954,730.00	9,829,933.48
210301	Гэрэл, цахилгаан	759,324.10	752,361.55
210302	Түлш, халаалт	8,459,534.00	8,347,646.31
210303	Цэвэр, бохир ус	734,956.80	729,010.52
210304	Байрны түрээс	915.10	915.10
2104	Хангамж, бараа материалын зардал	518,418.10	516,078.69
210401	Бичиг хэрэг	67,278.60	68,182.61
210402	Тээвэр, шатахуун	352,435.00	351,807.52
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	87,131.30	84,448.79
210404	Ном, хэвлэл	3,000.00	3,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,295.00	1,291.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,278.20	7,348.77
2105	Нормативт зардал	176,365.00	174,922.74
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	114,200.40	114,200.40
210502	Хоол, хүнс	38,806.90	38,806.90
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	23,357.70	21,915.44
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	215,422.50	211,559.26
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,960.70	6,960.70
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,956.40	2,703.60

Ховд аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210604	Урсгал засвар	205,505.40	201,894.96
2107	Томилолт, зочны зардал	103,913.00	101,704.30
210702	Дотоод албан томилолт	103,913.00	101,704.30
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,839,123.80	1,797,948.04
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,790,679.80	1,755,775.02
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	8,226.20	5,193.25
210803	Даатгалын үйлчилгээ	7,377.20	6,203.37
210804	Тээврийн хэрэгслийн татвар	4,777.70	3,970.61
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	1,153.50	938.45
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	19,432.30	18,732.30
210807	Газрын төлбөр	7,295.80	6,953.74
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	181.30	181.30
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,881,732.50	3,866,210.67
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,798,137.60	3,784,854.34
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	83,594.90	81,356.33
212	ТАТААС	52,684.40	52,684.40
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	52,684.40	52,684.40
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	52,684.40	52,684.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,776,484.90	3,337,695.99
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	2,753,082.90	2,430,983.60
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	2,753,082.90	2,430,983.60
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,023,402.00	906,712.39
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	211,045.00	128,900.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	48,651.00	48,651.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	363,762.30	360,678.22
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	278,389.10	251,022.80
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	121,554.60	117,460.37
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	19,796,821.60	17,221,828.97
220001	Барилга байгууламж	7,842,558.60	6,631,591.20
221001	Их засвар	3,789,605.20	3,245,704.11
222001	Тоног төхөөрөмж	1,661,378.20	1,825,356.18
223001	Бусад хөрөнгө	6,503,279.60	5,519,177.48
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	2,098,053.90	1,341,391.16
230001	Эргэж төлөгдөх зээл	2,098,053.90	1,341,391.16
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	54,609,426.30	50,283,245.55

Ховд аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	44,678,924.80	42,364,267.95
320001	Орон нутгийн төсвөөс	33,884,449.60	31,569,792.26
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	10,794,475.20	10,794,475.69
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	9,930,501.50	7,918,977.60
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	43,670.00	50,956.27
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,823,495.10	7,868,021.33
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	4,063,336.40	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		4,543,136.16
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		4,604,146.88
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	2,955.00	2,945.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	139	139
610001	Төсвийн байгууллага	139	139
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	1,408.00	1,403.00
620001	Удирдах ажилтан	170	170
620002	Гүйцэтгэх ажилтан	307	305
620003	Үйлчлэх ажилтан	765	762
620004	Гэрээт ажилтан	166	166
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	1,408.00	1,403.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	275	274
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	4	4
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	3	3
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	898	894
650010	Гэрээт ажилтан	81	81
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	147	147

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мян.төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	өмнөх он	тайлант он
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	9,394,341.7	7,665,337.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,983,569.6	7,639,752.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,229,666.2	7,134,527.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	487,844.3	433,534.8
210101	Үндсэн цалин	46,992.8	3,441.7
210102	Нэмэгдэл	382,708.6	-
210104	Урамшуулал	27,290.7	413,469.7
210105	Гэрээт ажлын хөлс	30,852.2	16,623.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,416.1	-
210201	Тэтгэврийн даатгал	25,290.5	-

Ховд аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210202	Тэтгэмжийн даатгал	281.4	-
210203	ҮОМШӨ-ний даатгал	225.1	-
210204	Ажилгүйдлийн даатгал	56.3	-
210205	Эрүүл мэндийн даатгал	562.8	-
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	72,370.9	645,752.3
210301	Гэрэл, цахилгаан	2,775.3	5,292.2
210302	Түлш, халаалт	65,695.6	640,460.1
210303	Цэвэр, бохир ус	3,900.0	-
2104	Хангамж, бараа материалын зардал	201,185.8	28,518.9
210401	Бичиг хэрэг	27,691.2	1,514.0
210402	Тээвэр, шатахуун	83,884.5	14,412.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	540.0	-
210404	Ном, хэвлэл	9,323.0	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	51,654.8	1,203.7
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	28,092.3	11,389.2
2105	Нормативт зардал	966,332.1	-
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	886,197.9	-
210502	Хоол, хүнс	53,228.7	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	26,905.5	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	182,769.9	12,936.6
210601	Багаж, техник, хэрэгсэл	78,497.3	-
210602	Тавилга	9,997.5	-
210604	Урсгал засвар	94,275.1	12,936.6
2107	Томилолт, зочны зардал	10,758.2	35,245.8
210702	Дотоод албан томилолт	10,758.2	35,245.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	623,952.2	612,074.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	619,860.0	612,074.1
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	4,092.2	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,658,036.7	5,366,464.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,454,735.5	5,346,009.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	203,301.2	20,455.0
212	ТАТААС	-	35,000.0
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	-	35,000.0
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	-	35,000.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,753,903.4	470,224.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,250,981.9	3,850.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	77.9	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	792,012.7	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	458,891.3	3,850.0

Ховд аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,502,921.5	466,374.7
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	-	179.1
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	32,000.1	-
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	1,470,921.4	466,195.7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	410,772.0	25,585.8
2200	Дотоод эх үүсвэрээр	410,772.0	25,585.8
220001	Барилга байгууламж	97,811.3	20,585.8
222001	Тоног төхөөрөмж	25,456.4	-
223001	Бусад хөрөнгө	131,134.4	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	156,369.9	5,000.0
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	9,394,520.7	7,665,158.9
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	9,394,520.7	7,665,158.9
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	296,109.2	793,017.6
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,596,375.1	4,385,958.1
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,191,442.8	1,542,493.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,373,186.5	943,690.2
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	2,937,407.1	-
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	179.1	(179.1)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	179.1
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	179.1	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Ховд аймаг нь “Хүний хөгжлийг дэмжсэн стандарттай шинэ Ховд” гэсэн эрхэм зорилгыг дэвшүүлэн эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах, биеийн тамир, спортыг эрүүл идэвхтэй амьдралын хэв маяг болгож хүн амд чанартай боловсрол эзэмших боломж бүрдүүлэн тэгш хамруулах, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж хүн амын хөгжлийг хангаж дундаж давхаргын хүрээг өргөжүүлэх, олон тулгуурт ногоон эдийн засагт түшиглэсэн, бүс нутгийн үр ашигтай хамтын ажиллагааг эрхэмлэсэн, үйлдвэрлэл, бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлж, хөрөнгө оруулалтын бодлогыг хэрэгжүүлэхэд төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчимд тулгуурлан, эдийн засгийн өсөлтийг хангах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдэл, ядуурлыг орон нутгийн түвшинд бууруулах зорилгыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Ховд аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч нь эдийн засгийн тогтвортой хөгжлийн бодлого, нийгмийн хөгжлийн бодлого, байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын бодлого, ил тод, нээлттэй засаглалын бодлогоор ангилан зорилтуудаа тодорхойлон үйл ажиллагааны чиглэл мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлэхээр ажиллажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Ховд аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч нь Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль зэрэг хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд 2022 онд Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд 4 удаа, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд 1 удаа, Төсвийн тухай хуульд 6 удаа, Шилэн дансны тухай хуульд 1 удаагийн нэмэлт өөрчлөлтүүд орж Төрийн хэмнэлтийн тухай хууль шинээр батлагдан мөрдөгдөж эхэлсэн байна.

Аймгийн Засаг даргаас хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Аймгийн Засаг даргаар батлуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу 2022 оны хяналт шалгалтын төлөвлөгөөгөөр хөдөөгийн 8 сумын 71 төсөвт байгууллага, тусгай сангууд, Жаргалант сумын ЗДТГ, ИТХ, тусгай сангууд, аймгийн төвийн 18 байгууллага, нийт 89 байгууллага, тусгай сангуудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийхээр төлөвлөж, төлөвлөгөө бүрэн хэрэгжиж, өргөдөл, гомдлын дагуу аймгийн төвийн 7 байгууллагад хяналт шалгалтын ажлууд хийгдсэн байна.

Санхүүгийн хяналт шалгалтаар орон нутгийн төсвийн орлогод 249.7 сая төгрөг, тухайн байгууллагын төсөвт орох, нөхөн олгох, сум хөгжүүлэх сангийн төсөвт оруулахаар 18.2 сая төгрөгийн, нийт 268.5 сая төгрөгийн акт тогтоож, улсын байцаагчийн 1 албан шаардлагаар 2.7 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар шийдвэрлэжээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Ховд аймгийн ТЕЗ нь санхүүгийн үйл ажиллагаандаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нэгдсэн журмаар батлуулж мөрдөөгүй ч батлагдсан хууль, тогтоол журмыг тухай бүр үйл ажиллагаандаа хэрэгжүүлж холбогдох стандарт, журмын дагуу гүйцэтгэж, нэгтгэлд хамрагддаг байгууллагууд бодлогын баримт бичгээ боловсруулан мөрдөж байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ховд аймгийн ТЕЗ-ын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар Засгийн газрын санхүүгийн Е-тайлан төсвийн гүйцэтгэлийн цахим программын хүрээнд Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаал, Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам, Төрийн сангийн санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх заавар аргачлал, Төсвийн гүйцэтгэлийн тайлан боловсруулах журам, төсвийн гүйцэтгэлийн тохируулга, кассын зарлагын нэгтгэлийн маягт, Эдийн засгийн ангилал батлах тухай, Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар, Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай, Төрийн сангийн үйл ажиллагааны журам, Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам, Засгийн газрын болон төсвийн байгууллагын дансыг Монгол банк, арилжааны банканд нээх, хаах тухай

заавар журмын хэрэгжилтийг ханган ажиллахад чиглэсэн Сангийн яамны нэгдсэн бодлогыг хүрээнд ажилласан байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Ховд аймгийн ТЕЗ-ийн 2022 оны санхүүгийн тайланг 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

ТЕЗ-ийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 113,419.3 сая төгрөгөөр буюу 55 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, урьдчилгаа, авлага, үндсэн хөрөнгө, бараа материал, урт, богино хугацаат өр төлбөр, өмчийн дансдууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая. төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө	0.3	0.3	-
Төрийн сангийн харилцахын үлдэгдэл	14,665.4	18,733.2	4,067.8
Арилжааны банкин дахь үлдэгдэл	117.4	108.6	(8.8)
Дүн	14,783.1	18,842.1	4,059.0
Үүнээс, байгууллагын төрлөөр			
Төсөвт байгууллага	4,555.5	4,604.1	48.6
Төсөл/ сан	4,291.4	4,619.9	328.5
Төрийн сан	5,818.6	9,509.4	3,690.8
ТӨҮГ болон ОНӨҮГ	117.6	108.7	(8.9)
Дүн	14,783.1	18,842.1	4,059.0

Эх сурвалж: Ховд аймгийн ТЕЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт хөрөнгө буурсан гол шалтгаан нь орон нутгийн тусгай шилжүүлгийн байгууллагууд нь улсын төсвөөс санхүүжилт авч тайлан балансаа харьяа салбарын яамандаа нэгтгэдэг болсон байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 14,783.1 сая, эцсийн үлдэгдэл 18,842.1 сая төгрөг болж, 4,059.0 сая төгрөгөөр буюу 27.5 хувиар өссөн байна.

Хүснэгт №2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө	0.3	0.3	-
Төрийн сангийн харилцахын үлдэгдэл	14,665.4	18,733.2	4,067.8
Арилжааны банкин дахь үлдэгдэл	117.4	108.6	(8.8)
Дүн	14,783.1	18,842.1	4,059.0
Үүнээс, байгууллагын төрлөөр			
Төсөвт байгууллага	4,555.5	4,604.1	48.6
Төсөл/ сан	4,291.4	4,619.9	328.5
Төрийн сан	5,818.6	9,509.4	3,690.8
ТӨҮГ болон ОНӨҮГ	117.6	108.7	(8.8)
Дүн	14,783.1	18,842.1	4,059.0

Эх сурвалж: Ховд аймгийн ТЕЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдлээс ОНӨААТҮГ-ын 0.3 сая төгрөг нь касст байршиж буй,

Ховд аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

арилжааны банкны үлдэгдэл 108.6, төрийн сан банканд байршиж буй 18,733.2 сая төгрөгөөс 50.7 хувь нь төрийн санд, 24.6 хувь нь төсөвт байгууллагад, 24.7 хувь нь төсөл сангийн дансанд байршиж байна.

Тайлант онд орон нутгийн төсвийн орлого 84,416.8 сая төгрөгөөр бүрдүүлж 42,109.1 сая төгрөгийг харьяа байгууллагуудын урсгал санхүүжилтэд, 36,695.8 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын санхүүжилтэд, 2,592.9 сая төгрөгийг Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн санхүүжилтэд зарцуулж оны эцэст 18,842.1 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

- Булган, Үенч, Дуут, Мөст сумд түүхт ойг тэмдэглэн өнгөрүүлэх зорилгоор хувь хүний нэрээр арилжааны банкинд данс нээн орлого бүрдүүлэн зарцуулсан, хяналт хэрэгжүүлээгүй 658.6 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийг бүрдүүлж, төрийн сангийн хяналтгүйгээр зарцуулсан,

3.4.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 9,920.7 сая төгрөг, оны эцсийн үлдэгдэл 9,716.4 сая төгрөг болж 204.3 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №3 Авлагын үлдэгдэл

(сая.төгрөг)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	92.3	15.4	(76.9)
Төлбөртэй үйлчилгээний авлага	1,211.2	162.9	(1,048.3)
Татаас, санхүүжилтийн авлага	7.7		(7.7)
Зээлийн хүүгийн авлага	112.5	125.1	12.6
Дансны авлага /ТӨҮГ/	301.5	278.2	(23.3)
Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/	15.5	0.1	(15.4)
Байгууллагаас авах авлага	3,972.8	4,659.0	686.2
Хүмүүсээс авах авлага	486.3	299.6	(186.7)
Зээлийн авлага	3,720.9	4,176.1	455.2
Дүн	9,920.7	9,716.4	(204.3)
Үүнээс, байгууллагын төрлөөр			-
Төсөвт байгууллага	5,898.3	6,094.1	195.8
Төсөл/ сан	3,720.9	2,091.7	(1,629.2)
Төрийн сан		1,251.5	1,251.5
ТӨҮГ болон ОНӨҮГ	301.5	279.1	(22.4)
Дүн	9,920.7	9,716.4	(204.3)

Эх сурвалж: Ховд аймгийн ТЕЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төлбөрт үйлчилгээний авлага 1,048.3, ажиллагчидтай холбогдсон авлага 76.9, татаас санхүүжилтийн авлага 7.7 сая төгрөгөөр тус тус буурсан, байгууллагаас авах авлага 686.2, зээлийн авлага 455.2 сая төгрөгөөр өссөн гол шалтгаан нь Үенч сум 114.4, Булган сум 146.7, Буянт сум 63.3, Дарви сум 54.5, Зэрэг сум 34.3, Жаргалант сум 179.5, Мөст сум 41.8 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Хоршоо хөгжүүлэх сангаас зээл олгосонтой холбоотой байна.

Төсөл сангаас авах авлага өмнөх оноос 1,629.2 сая төгрөгөөр буурсан, төрийн сангийн авлага 1,251.5 сая төгрөгөөр өссөн нь Шим ус ОНӨААТҮГ-ын урт хугацаат зээл, зээлийн хүүгийн өр төлбөрийг аймгийн ААНОАТ-ын орлогоос Сангийн яам суутган тооцон авсантай холбоотой нэмэгдсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- Чандмань БИТ 6.3 сая, Эмийн эргэлтийн сангийн 25.6, Үенч Эрчим хүч ТӨҮГ-ын 10.3 сая төгрөгийн нийт 42.2 сая төгрөгийн барагдахгүй он удаан жил болсон найдваргүй авлага байна.
- Нийт авлагын 2.7 хувь буюу 265.9 сая төгрөгийн авлага нь Мянган Угалзат, Шим ус ОНӨААТҮГ, Булган сумын Минжит хот тохижилт, Ховд суварга, Цэцэг мянган сутайн буян, Шинэ Ховд Баруун бүсийн хөгжлийн корпораци, Шинэ Ховд Жаргалант ТҮК ОНӨААТҮГ, Эв зөийн хүч худалдааны төвтэй холбоотой байна.

3.4.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 1,743.8 сая, эцсийн үлдэгдэл 3,528.9 сая төгрөг болж 1,785.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Урьдчилгаа дансны үлдэгдэл

(сая.төгрөг)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын сан	604.8	602.4	(2.4)
Урьдчилж гарсан зардал	979.4	2,062.0	1,082.6
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	1.7	33.0	31.3
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	151.8	824.0	672.2
Цалингийн урьдчилгаа	6.1	7.5	1.4
Дүн	1,743.8	3,528.9	1,785.1
Үүнээс, байгууллагын төрлөөр			
Төсөвт байгууллага	1,741.8	3,526.4	1,784.6
ТӨҮГ болон ОНӨҮГ	2.0	2.5	0.5
Дүн	1,743.8	3,528.9	1,785.1

Эх сурвалж: Ховд аймгийн ТЭЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд урьдчилж гарсан зардал 1,082.6, бараа материал бэлтгэх урьдчилгаа 31.3, үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа 672.2 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь аймгийн ЗДТГ-ын авлага 521.4 сая төгрөгөөр өссөн нь “Орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд айл өрхүүдэд цэвэр усны шугам татах ажил дуусаагүй он дамжсан, Хөшөөт хөгжлийн сангийн авлага 272.3 сая төгрөгөөр буюу сангийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудыг хүлээн аваагүй, Жаргалант сумын авлага өмнөх оноос 668.5, Мянгад сум 61.1, Мөнххайрхан сумын авлага 136.1 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажлууд бүрэн хийгдээгүй, хүлээлгэн өгөөгүйтэй холбоотой байна.

3.4.4 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материал оны эхэнд 7,359.5 сая төгрөг, оны эцэст 3,269.5 сая төгрөгийн болж 4,090.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №5 Бараа материалын үлдэгдэл (сая.төгрөг)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	1,473.5	1,048.1	(425.4)
Хангамжийн материал	5,591.7	1,721.9	(3,869.8)
Нөөцийн бараа	294.3	499.5	205.2
Дүн	7,359.5	3,269.5	(4,090.0)
Үүнээс, байгууллагын төрлөөр			
Төсөвт байгууллага	6,246.0	1,540.5	(4,705.5)
Төсөл/ сан	108.3	127.1	18.8
ТӨҮГ болон ОНӨҮГ	710.9	1102.4	391.5

Ховд аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Нөөцийн бараа	294.3	499.5	205.2
Дүн	7,359.5	3,269.5	(4,090.0)

Эх сурвалж: Ховд аймгийн ТЕЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд 3,224.2 сая төгрөгөөр худалдан авсан, 192.8 сая төгрөгөөр хандиваар үнэ төлбөргүй, 321.6 сая төгрөгөөр бусад бүгд 3,738.6 сая төгрөгөөр нэмэгдэж, 2,841.5 сая төгрөгийн бараа материалыг байгууллагын үйл ажиллагаанд зарцуулж 55.9 сая төгрөгийг бараа материалыг бусад байгууллагуудад шилжүүлсэн, 4,829.7 сая төгрөгийн бараа материалыг бүтцийн өөрчлөлтөөр, 101.4 сая төгрөгийг бусад нийт 7,828.5 сая төгрөгийн бараа материалын зарлага гаргасан байна.

Аудитын илрүүлэлт:

- Эмийн эргэлтийн сан 99.2, Үенч Эрчим хүч ТӨҮГ-ын 0.7 сая төгрөгийн нийт 99.9 сая төгрөгийн бараа материал бодитоор оршин байхгүй, тухайн байгууллагад үйл ажиллагаа явуулаагүй,
- Эрдэнэбүрэн сумын ЗДТГазар нь 10.0 сая төгрөгөөр тэжээл худалдан авсан бараа материалын тайланд тусгаагүй орхигдуулсан,

3.4.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл цэвэр дүнгээрээ 220,960.4 сая оны эцэст 105,991.0 сая төгрөг болж 114,969.4 сая төгрөгөөр буюу 47.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №6 Үндсэн хөрөнгө, хуримтлагдсан элэгдлийн үлдэгдэл (сая.төгрөг)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	272,139.50	143,170.2	(128,969.3)
Хуримтлагдсан элэгдэл	-65,825.6	-46,619.2	19,206.4
Биет бус хөрөнгө	14,646.5	9,440.0	(5,206.5)
Хуримтлагдсан элэгдэл	-192.1	-59.9	-132.2
Дүн	220,960.4	105,991.0	114,969.4
Үүнээс, байгууллагын төрлөөр			
Төсөвт байгууллага	267,748.4	121,838.2	145,910.2
Хуримтлагдсан элэгдэл	-61,340.9	-40,970.6	-20,370.3
Төсөл/ сан	1,548.4	1,540.2	8.2
Хуримтлагдсан элэгдэл	-133.9	-165.3	31.4
ТӨҮГ болон ОНӨҮГ	17,489.2	29,231.9	-11,742.7
Хуримтлагдсан элэгдэл	-4,350.8	-5,483.4	1,132.6
Дүн	220,960.4	105,991.0	114,969.4

Эх сурвалж: Ховд аймгийн ТЕЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд 111.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг худалдан авсан, 940.9 сая төгрөгөөр үнэ төлбөргүй хандиваар, 3,484.5 сая төгрөгөөр балансаас балансад шилжүүлэн авсан, 14,430.3 сая төгрөгөөр бусад нийт 18,967.6 сая төгрөгөөр нэмэгдэж, 338.1 сая төгрөгийн хөрөнгийг акталсан, 150,386.1 сая төгрөгийн хөрөнгийг бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн, 50.3 сая төгрөгийн хөрөнгийг бусад бүгд 153,143.3 сая төгрөгөөр хасагдсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Аймгийн ИТХ-ын даргын А/50 тоот захирамжаар аймгийн ЗДТГ-аас 40.0 сая төгрөг анхны өртөгтэй, 28.0 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй ковш тээврийн хэрэгслийг Шим ус

Ховд аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

ОНӨААТҮГ-т балансаас балансад шилжүүлэх тухай шийдвэр гарсан ЗДТГ-ын санхүүгийн тайланд шилжүүлснээр бүртгээгүй,

- Дуут сумын ЗДТГазар газар эзэмших эрхийн 86.9 сая төгрөгийн биет хөрөнгийг үнэ төлбөргүй хандиваар бүртгэсэн,
- Манхан сумын ЗДТГ орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 48.6 сая төгрөгийн өртөгтэй “Тамгат цогцолбор”-ын авто зогсоолыг данс бүртгэлд тусгаагүй,
- Эмийн эргэлтийн сангийн 12.5, Үенч Эрчим хүч ТӨҮГ-ын 840.8, нийт 853.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө данс бүртгэлтэй ч бодитоор оршин байгаа эсэх нь тодорхойгүй,
- Мянган Угалзат ОНӨААТҮГ-ын Нэвт амралтын газарт 2022 оны 6 сард гал гарч 669 нэр төрлийн 426.8 сая төгрөгийн хөрөнгө шатсан бөгөөд холбогдох байгууллагын дүгнэлт гарсан байтал оршин байхгүй хөрөнгийг хэрхэх талаарх шийдвэрийг хариуцсан байгууллагуудаас гаргаагүй тул бүртгэлтэй байгаа,
- Аймгийн Орон нутгийн өмчийн газраас хөрөнгийн бүртгэлд тавих хяналт сул, нэгтгэсэн хөрөнгийн мэдээ тайланг аудитын хугацаанд ирүүлээгүй, өмнөх онуудын аудитаар үндсэн хөрөнгийн бүртгэлд байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 0 үлдэгдэлтэй хөрөнгийг дахин үнэлж бүртгэх зөвлөмжийг хэрэгжүүлээгүй,

3.4.6 Өр төлбөр

Нийт өр төлбөр эхний үлдэгдэл 7,128.6 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 5,217.7 сая төгрөг болж 1,910.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №7 Нийт өр төлбөрийн үлдэгдэл

(сая.төгрөг)

<u>Үзүүлэлт</u>	<u>Эхний</u>	<u>Эцсийн</u>	<u>Өссөн+</u>
	<u>үлдэгдэл</u>	<u>үлдэгдэл</u>	<u>Буурсан -</u>
<u>Богино хугацаат өр төлбөр дүн</u>	6,185.2	5,202.70	(982.5)
Ажилчидтай холбогдсон өглөг	92.2	32.6	(59.6)
Бараа үйлчилгээний зардлын өглөг	141.2	24.7	(116.5)
Хөрөнгө бэлтгэхтэй холбоотой өглөг	11.4	78.6	67.2
Байгууллагад өгөх өглөг	1,557.4	641.5	(915.9)
<u>Хүмүүст өгөх өглөг</u>	18.5	17.7	(0.8)
<u>Бусад өглөг</u>	394.6	414.9	20.3
<u>Урьдчилж орсон орлого</u>	3,969.9	3,992.7	22.8
<u>Урт хугацаат өр төлбөрийн дүн</u>	943.4	15.0	(928.4)
<u>Шим-Ус ОНӨААҮГ</u>	928.4		(928.4)
<u>Чандмань БИТ</u>	15.0	15.0	-
<u>Нийт дүн</u>	7,128.6	5,217.7	(1,910.9)
<u>Үүнээс, байгууллагын төрлөөр</u>			
Төсөвт байгууллага	107.5	118.0	10.5
Төсөл, сан	4,020.8	4,057.1	36.3
Төрийн сан	1,332.7	312.6	(1,020.1)
ТӨҮГ болон ОНӨҮГ	724.2	715.0	(9.2)
ДҮН	6,185.2	5,202.7	(982.5)
Урт хугацаат өр төлбөрийн дүн /ТӨҮГ болон ОНӨҮГ	943.4	15.0	(928.4)
Нийт дүн	7,128.6	5,217.7	(1,910.9)

Эх сурвалж: Ховд аймгийн ТЕЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Ховд аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Богино хугацаат өр төлбөр 5,217.7 сая төгрөг болж өмнөх оноос 1,910.9 сая төгрөгөөр буюу байгууллагад өгөх өр 915.9 сая, ажилчидтай холбогдсон өр 59.6 сая, бараа үйлчилгээний зардлын өглөг 116.5 сая, хүмүүст өгөх өр төлбөр 0.8 сая төгрөгөөр тус тус буурсан.

Хөрөнгө бэлтгэхтэй холбоотой өр төлбөр 67.2, бусад өглөг 20.3, урьдчилж орсон орлого 22.8 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Барьцаа дансанд хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний ажлын гүйцэтгэлийн баталгаа 3,992.7 сая төгрөг байршуулж өглөгөө бүртгэсэн тул дараагийн онд барагдах боломжтой өглөг байна.

Тайлант оны эцэст Шим-Ус ОНӨААТҮГ-ын 928.3 сая төгрөгийн урт хугацаат өр төлбөрийг богино хугацаатай өр төлбөрийн ангилалд шилжүүлсэн, тус зээлтэй холбоотой 323.2 сая төгрөгийн зээлийн хүүг болон Чандмань сумын БИТ төвийг 15.0 сая төгрөгөөр барихад зориулан нийт 943.4 сая төгрөгийн зээл олгогдсон байна.

Нийт өглөгийн 36.2 хувь буюу 1,888.8 сая төгрөгийн богино хугацаат өр төлбөр нь Мянган Угалзат, Шим ус ОНӨААТҮГ, Булган сумын Минжит хот тохижилт, Ховд суварга, Цэцэг мянган сутайн буян, Шинэ Ховд Баруун бүсийн хөгжлийн корпораци, Шинэ Ховд Жаргалант ТҮК ОНӨААТҮГ, Эв эеийн хүч худалдааны төвтэй холбоотой үүссэн байна.

Аудитын илрүүлэлт:

- Эмийн эргэлтийн сангийн 58.5 сая, Чандмань БИТ 9.3, Үенч эрчим хүч ТӨҮГ-ын 17.3 сая төгрөг нийт 85.1 сая төгрөгийн өр төлбөр байгаа нь он дамжин барагдах эсэх нь тодорхойгүй үйл ажиллагаа нь хэвийн бус,
- Ховд агро парк ХХК-ын газар тариалангийн үйл ажиллагаа явуулж буй газар нь 2016 оны 04 дүгээр сарын А/29 дугаар захирамжаар 15 жилийн хугацаатай эзэмшүүлэхээр захирамж гарч тухайн захирамжийг 2018 оны 09 дүгээр сарын 21 ны өдрийн А/106 тоот захирамжаар хүчингүй болгосон байхад тухайн газрын гэрчилгээгээр ХААДС-с барьцаалбар үүсгэн 935.9 сая төгрөгийн үнэ бүхий усалгааны системийн тоног төхөөрөмжийг урьдчилгаа төлбөргүй жилийн 6 хувийн хүүтэй гэрээ байгуулан авсан байна.Энэхүү өрийг нэгтгэсэн тайланд бүртгээгүй бөгөөд Өрийн удирдлагын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.2¹, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3²-д заасан бүрэн эрхээ хэрэгжүүлж өрийг барагдуулах талаар тодорхой шийдвэрийг ТУЗ -ын зүгээс хяналт хэрэгжүүлэн цаашидын өр төлөх эрсдэлийг бууруулах шаардлагатай байна.

3.4.7 Засгийн газрын хувь оролцоо

Хүснэгт №8 Засгийн газрын оруулсан капиталын үлдэгдэл (сая.төгрөг)

<u>Үзүүлэлт</u>	<u>Эхний үлдэгдэл</u>	<u>Эцсийн үлдэгдэл</u>	<u>Өсөлт/+, бууралт /-</u>
Засгийн газрын оруулсан капитал	94,052.0	53,972.0	(40,080.0)
Хуримтлагдсан үр дүн	99,193.0	71,391.7	(27,801.3)
Дахин үнэлгээний нэмэгдэл	54,393.8	10,766.6	(43,627.2)
Дүн	247,638.8	136,130.3	(111,508.5)
Үүнээс, байгууллагын төрлөөр			
Төсөвт байгууллага	233,969.3	114,566.2	(119,403.19)
ТӨҮГ болон ОНӨҮГ	<u>13,669.5</u>	<u>21,564.1</u>	7,894.6
Дүн	247,638.8	136,130.3	(111,508.5)

Эх сурвалж: Ховд аймгийн ТЕЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дуут сумын ЗДТГ-ын биет бус хөрөнгө буюу газрыг 86.8 сая, Шим ус ОНӨААТҮГ-ын 7,107.8 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгасан, Шинэ Ховд баруун бүсийн

¹ тухайн орон нутагт зээллэгийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах, үйл ажиллагаанд хяналт тавих;

² 14.2.3.өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах;

хөгжлийн корпорацийн 966.6 сая төгрөг нийт 8,161.2 сая төгрөгөөр Засгийн газрын оруулсан капитал нэмэгдсэн байна

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтөөр 94 тусгай шилжүүлгийн байгууллагуудын үндсэн хөрөнгө шилжүүлсэнтэй холбоотой Засгийн газрын оруулсан капитал данс 48,241.3 сая, дахин үнэлгээний нэмэгдэл данс 43,618.1 сая төгрөгөөр тус тус буурсан, хуримтлагдсан үр дүн 91,025.3 сая төгрөгөөр өссөн, Мөнххайрхан сумын ЗДТГ-ын хөрөнгө акталсантай холбоотой 9.1 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

Тайлант үеийн үр дүн 118,827.2 сая төгрөгөөр хуримтлагдсан үр дүн буурсан байна. Энэ нь дээрх улсын төсвийн байгууллагуудын үндсэн хөрөнгө, бараа материал, авлага, өглөгийн дансдын эхний үлдэгдлийг шилжүүлсэнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

- *Жаргалант сумын ТТЗ нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих байгууллагуудын санхүүгийн тайланг шилжүүлэхдээ өмчийн өөрчлөлтийн тайланд хаалтын тайлан хийхдээ нягтлан бодох бүртгэлийн бодлого өөрчлөлт дансанд тусгаагүй, өмнөх үеийн хуримтлагдсан үр дүн дансыг 14,371.8 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн тул залруулга хийлгэлээ.*

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 28,232.7 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 13,490.8, үйл ажиллагааны орлогоос 39.4 сая төгрөгөөр, нийт зарлагыг 41,762.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид 2021 оны 8 дугаар сарын 12-ны 1/225 тоот албан бичгээр хүргүүлсэн байна.

Аймгийн ИТХ-ын 2021 оны 12 сарын 04-ны өдрийн №05/07 тогтоолоор аймгийн төсвийн суурь орлого, суурь зарлагыг анх 56,941.2 сая төгрөгөөр баталсан 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн №07/02 тогтоолоор суурь орлого, зарлагыг 54,609.4 сая төгрөг болгон 1,631.8 сая төгрөгөөр бууруулан баталжээ. Аймгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийг 6,890.4 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлгийг 10,794.5 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 2,331.7 сая төгрөгөөр бууруулж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 22 хөтөлбөрийн 33 арга хэмжээг санхүүжүүлэхээр 6,890.4 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүгийн дэмжлэгээр, 10,794.5 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн орлогын шилжүүлгээр, орон нутгийн төсвөөс 32,861.3 сая, бусад эх үүсвэрээс 4,063.3 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 6,890.4 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авч, 10,794.5 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн орлогын шилжүүлгээр санхүүжилт авч орон нутгийн төсөв болон бусад эх үүсвэрээр 32,599.1 сая төгрөгийн орлого бүрдүүлэн нийт 50,284.0 сая төгрөгийн эх үүсвэр бүрдүүлсэн байна.

Төсвийн орлого гүйцэтгэлээр 56,246.0 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 1,636.6 сая төгрөг буюу 3 хувиар давж, төсвийн зарлага гүйцэтгэлээр 49,371.3 төгрөгийг зарцуулж, 5,238.1 сая төгрөг буюу 9.6 хувиар хэмнэн зарцуулсан байна.

Хүснэгт 9. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /сая. төгрөг/

Д/д	Хэрэгжүүлсэн хөтөлбөр	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хувь
-----	-----------------------	------------------	-----------	------

Ховд аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	Авто зам	1,168,000.00	638,427.60	54.7
2	Авто тээврийн хяналт, зохицуулалт, үйлчилгээ, нийтийн тээвэр	5,500.00	5,500.00	100.0
3	Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр	430,368.30	4,904.00	1.1
4	Ахмад настны хөгжил хамгаалал	111,284.50	110,829.00	99.6
5	Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх	488,764.10	427,147.10	87.4
6	Биеийн тамир спорт	512,487.50	508,187.70	99.2
7	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх	155,450.00	145,910.60	93.9
8	Ерөнхий боловсрол	6,458,356.60	6,384,649.20	98.9
9	Мал аж ахуйг хөгжүүлэх	455,505.10	455,505.10	100.0
10	Нийгмийн халамж	506,441.50	424,250.00	83.8
11	Ойжуулалт	73,692.10	73,692.10	100.0
12	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа	1,935,935.80	1,812,885.20	93.6
13	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	34,736,245.60	30,905,344.90	89.0
14	Санхүүгийн хяналт, дотоод аудит, эрсдэлийн удирдлага	164,285.70	164,285.70	100
15	Соёл урлаг	988,424.10	964,554.80	97.6
16	Сургуулийн өмнөх боловсрол	2,346,919.90	2,320,228.90	98.9
17	Суурин газрын усан хангамж	55,320.00	55,320.00	100.0
18	Мэргэжлийн боловсрол	638,046.60	636,171.30	99.7
19	Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	449,259.80	446,931.10	99.5
20	Хот байгуулалт, тохижилт	368,696.30	368,696.30	100.0
21	Эмнэлгийн тусламж үйлчилгээ	545,236.10	510,336.40	93.6
22	Ангилалдаагүй бусад	2,015,207.10	2,007,546.50	99.6
	Нийт дүн	54,609,426.70	49,371,303.50	90.5

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн тайлангаар БОАЖЯ-аас 10.0, Булган, Үенч, Мөст, Дуут сумдын түүхт ойн хандиваар 658.6, Засгийн газраас хэрэгжүүлж буй ундны усны хөнгөлөлт, хог хаягдлын хураамж зэргээс 124.4, аймгийн ЗДТГ, ОНХС, Хөшөөт хөгжлийн сан, ОНХО, Засаг дарга, техник хяналтын зардлаас 4,386.0, Статистик, Онцгой байдлын газар, харьяа дээд шатны байгууллагуудаас 1,542.5, туслах үйл ажиллагааны орлогоос 943.7 сая төгрөг нийт 7,665.2 сая төгрөгийн орлого бүрдүүлэн 7,199.0 сая төгрөгийг зарцуулж орон нутгийн төсвийн орлогын нэмэлт дансанд 466.2 сая төгрөгийг төвлөрүүлж, ТЕЗ-ийн нэгтгэсэн тайланд 312.6 сая төгрөгийг авлага, өглөгөөр бүртгэсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Ховд аймгийн Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, цаашид анхаарал хандуулж ажиллах асуудлуудын талаарх зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг ахлах аудитор Д.Нарантуул, аудитор Ц.Гантулга, С.Оюунжаргал, М.Энхжаргал нар 2023 оны 04 дүгээр сарын 01-нээс 2023 оны 04 дүгээр сарын 20-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Ховд аймгийн Засаг дарга нь 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 31-ны өдрийн 1/520 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “бага” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 89,206.7 сая төгрөгөөс 2 хувиар буюу 1,784.1 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага аймгийн ИТХ-ын 2022 оны 7 дугаар хуралдаанаар цалин тэтгэвэр тэтгэмжээс бусад зардлыг 5-6 хувиар тооцон 83.1 сая төгрөгөөр бууруулан тодотгон хэрэгжүүлэн ажилласан байна.

Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль 2022 оны 05 дугаар сарын 01-ээс хэрэгжиж эхэлснээр аймгийн орлогчийн даргын орон тоог /орлогч, нарийн бичиг, жолооч цомхотголд орсноор 20.0 сая төгрөгийн цалингийн зардлын хэмнэлт бий болсон байна.

Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 124.8 сая төгрөгөөр буюу гэрэл цахилгааны зардлаас 6.9, түлш халаалтын зардлаас 111.9, цэвэр, бохир усны зардлаас 5.9 сая төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 2.3, нормативт зардлыг 1.4, эд хогшил, урсгал засварын зардлыг 3.8, томилолтын зардлыг 2.2, сая төгрөгөөр төгрөгөөр тус тус хэмнэсэн байна

Албан тушаалын автомашинтай холбоотой шатахууны зардлын хэмнэлт бий болоогүй гол шалтгаан нь шатахууны үнийн өсөлт нөлөөлсөн байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.3 дах заалтыг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын 2022 оны 7 дугаар сарын 04-ний А/423 захирамжаар авто машины хэрэглээг хуулиар хязгаарласантай холбогдуулан аймгийн хэмжээнд 462 ширхэг тээврийн хэрэгсэл ашиглагдаж байгаагаас 40 тээврийн хэрэгслийг татан төвлөрүүлэн, Засгийн газрын 2022 оны 204 тоот тогтоолын дагуу худалдан борлуулах, Засгийн газрын тогтоолоор

зөвшөөрөгдсөн бусад хэрэгцээтэй байгууллагуудад шилжүүлэх тээврийн хэрэгслийн судалгаа гаргасан байна.

Хүснэгт 10. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн алдаа, зөрчил /сая. төгрөг/

Хуулийн зүйл	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ТХХ 6.2.	1	6.1			1	6.1		
ТХХ 6.3.	1	2.6					1	2.6
ТХХ 12.1.3.	1	0.3					1	0.3
ТХХ 12.1.4.	8	70.9	2	0.9	1	22.3	6	47.7
ТХХ 15.1.5.	3	1.3	3	1.3				
ТХХ 15.1.7.	1	0.8	1	0.8				
ДҮН	16	82.0	6	3.0	2	28.4	8	50.6

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтуудыг мөрдөөгүй зөрчил илэрч ТШЗ-ын санхүүгийн тайлангийн аудитаар 3.0 сая төгрөгийн 3 төлбөрийн акт, 28.4 сая төгрөгийн 2 албан шаардлага, 50.6 сая төгрөгийн 8 заалт зөвлөмж өгөгдсөн байна. Үүнд:

• **Аудитын илрүүлэлт:**

- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-д “Аймаг, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргаас бусад этгээд албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно” гэсэн заалтыг Жаргалант сумын ЗДТГ-ын автомашин унах эрхгүй албан тушаалтнууд 6.1 сая төгрөгийн шатахууныг зарцуулсан,
- Хуулийн 6.3-д “Энэ хуулийн 3.1-д заасан этгээд орон нутагт албан томилолтоор, хуульд заасан эрх бүхий этгээд газар дээрх хяналт шалгалтаар ажиллахад хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, эсхүл төрийн болон орон нутгийн өмчийн авто тээврийн байгууллагаар үйлчлүүлэхээс бусад тохиолдолд автомашин ашиглахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчин Ойн анги 2.6 сая төгрөгийн шатахууны зардал зарцуулсан,
- Хуулийн 12.1.3-д “хэвлэлийн захиалгын төлбөр,” гэж заасан Мөнххайрхан сумын ЗДТГазар нь байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоогүй хэвлэлийг зардалд 0.3 сая төгрөгийг зарцуулсан,
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-д “зөвшөөрөөгүй бусад” зардлыг гаргахгүй гэсэн заалтыг Жаргалант сумын ЗДТГ, Үенч сумын ЗДТГ, ИТХ, Дөргөн сумын ЗДТГ, ИТХ, Алтай сумын ЗДТГ, Эрдэнэбүрэн сумын ЗДТГ, Булган сумын ЗДТГ, Манхан сумын ЗДТГ, ИТХ, Дарви сумын ЗДТГ, ИТХ, Жаргалант сумын ИТХ зэрэг байгууллагууд нийт 47.7 сая төгрөгийг албан хэрэгцээнд шаардлагатай эсэх нь тодорхой бус материал худалдан авсан, уралдаан тэмцээний зардал санхүүжүүлсэн, хандив тусламж олгосон, сумын ойн арга хэмжээнд, бэлэг дурсгалын худалдан авсан, төсвийн үрэлгэн зардлыг санхүүжүүлсэн,
- Мөн хуулийн 15.1.5 дахь заалтыг Дарви сумын ЗДТГ, ИТХ, Жаргалант сумын ИТХ зэрэг байгууллагуудад 1.3 сая төгрөгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авсан, төсвийг үр ашиггүй зарцуулсан,
- Орон нутгийн өмчийн газар хуулийн 15.1.7 дахь заалтыг зөрчин 0.8 сая төгрөгийн төсвийн хөрөнгөөр хориглосон бараа материал худалдан авсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх

дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 156 мэдээллээс 84 мэдээллийг хугацаандаа оруулсан, 51 мэдээллийг хугацаа хоцроосон, өр авлага үүсгэсэн шийдвэр, тендерийн ерөнхий мэдээлэлтэй холбоотой 13 мэдээг байршуулаагүй, хугацаа болоогүй 8 мэдээлэл байна.

Аймгийн хэмжээнд Хоршоо хөгжүүлэх сангийн Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг мэдээлэх тусгай цэсгүйгээс тайлант онд орсон орлогын гүйлгээ, зээлдэгчийн талаарх мэдээллийг мэдээлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

4.4.2.1 ТБОНӨХБАУХАТ хуулийн дагуу ОНХС-ийн хөрөнгөөр 215.0 сая төгрөгийн 4 арга хэмжээг харьцуулалтын аргаар, 75.0 сая төгрөгийн 2 арга хэмжээг зөвлөх сонгох бага үнийн аргаар, 286 сая төгрөгийн 7 арга хэмжээг шууд гэрээ байгуулах замаар худалдан авч хэрэгжүүлсэн байна.

ОНХС-ийн хөрөнгөөр тайлант онд хэрэгжсэн Нийтийн халуун ус, сауны цогцолборын барилга, Бугат багийн Хүүхдийн тоглоомын талбай байгуулах ажлын анх батлагдсан төсөвт өртгийг нэмэгдүүлэн баталсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 3.1.5-д “хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ хуулиар батлагдсанаас хойш түүний төсөвт өртөг нэмэгдүүлэх үр дагавар бүхий нэмэлт шаардлагыг зохиогч, ашиглагч, захиалагчийн хяналт тавих этгээд гаргахгүй байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Хүснэгт 11. Бусад хууль, тогтоомж /сая. төгрөг/

Д/д	Төсөл, арга хэмжээ	Анх батлагдсан төсөвт өртөг /2021 /	2022	2023
1	Нийтийн халуун ус, сауны цогцолборын барилга	1,650.00	-	1,000.00
2	Бугат багийн Хүүхдийн тоглоомын талбай байгуулах	65	30	-
Нийт		1,715.00	30	1,000.00

4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 214.5 сая төгрөгийн төлбөрийн акт, 1,622.2 сая төгрөгийн 1 албан шаардлага, 752.8 сая төгрөгийн 8 заалт зөвлөмж өгөгдөж хэрэгжүүлэх шатандаа явагдаж байна.

Хүснэгт 12. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт /сая. төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Акт	1	214.5			1	214.5
Албан шаардлага	1	1,622.2			1	1,622.2

Ховд аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Зөвлөмж	8	752.8	3	317.9	5	434.9
Нийт дүн	10	2,589.5	3	317.9	7	2,271.6

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн төлбөрийн акт, албан шаардлагыг хэрэгжүүлэхээр дараах арга хэмжээг авч ажилласан байна. Үүнд:

1. Ховд аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 153/ШШ2022/00473 тоотой шийдвэрээр Энтү ХХК-аас 212.4 сая төгрөгийг аймгийн ЗДТГ-т олгохоор шийдвэрлэсэн ч одоог хүртэл төсөвт буцаан төлөөгүй байна.
2. ЗД-ын 2022 оны А/506 тоот захирамжаар 17 хүний бүрэлдэхүүнтэй авлага барагдуулах ажлын хэсэг байгуулсан, 2022 оны 153/ШШ2022/00126 тоот тогтоолоор Цогт Барс ХХК-ний 35.0 сая төгрөгийг эвлэрлийн гэрээгээр 2024 оны 1 сараас эхлэн төлөхөөр гэрээ байгуулсан. Бусад авлагатай холбоотой асуудлыг шийдвэрлүүлэхээр 2023 оны 4 дүгээр сард хуулийн байгууллагад шилжүүлсэн байна. Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.2³-д өөрчлөлт орсноор зураг төсвийн 715.1 сая төгрөгийн авлага барагдах боломжтой байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар аймгийн авлага, өр төлбөрийг барагдуулах, татан буугдсан болон үйл ажиллагаа нь зогссон орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын асуудлыг хянан үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4.7 Харьяа байгууллагуудын аудитын дүнгийн талаар

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 43 төсвийн байгууллага, 17 төсвийн төвлөрүүлэн захирагч, 12 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 36 тусгай сан, нийт 108 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 108 байгууллага аудитад хамрагдаж, Үенч-Эрчим хүч, Чандмань БИТ, Үенч Мөнх ундарга баялаг, Эв эеийн хүч ОНӨААТҮГ-ууд нь үйл ажиллагаа явуулдаггүй тул хамрагдаагүй байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас 79 байгууллагыг түүвэрт хамруулж, 29 байгууллагад дүгнэлт хүргүүлээ. Үүнд: “Зөрчилгүй”- 15, “Хязгаарлалттай”-14 /аймгийн ЗДТГ, Жаргалант сумын ЗДТГ, аймгийн ИТХ, Буянт, Дарви, Манхан, Мөст, Зэрэг, Жаргалант, Үенч, Цэцэг сумдын ТТЗ, Мянган Угалзат ОНӨААТҮГ, Шинэ Ховд баруун бүсийн хөгжлийн корпораци, Хөшөөт хөгжил сан / санал дүгнэлт өгсөн байна.

Хүснэгт 13. Аудитад хамрагдсан харьяа байгууллагын судалгаа алдаа, зөрчил

/сая.төгрөг/

д/д	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа зөрчлийн дүн		Үүнээс							
				залруулга		төлбөрийн акт		албан шаардлага		зөвлөмж	
		тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
1	ТШЗ	23	3,601.0	9	2047.2	5	27.6	9	1526.2		
2	ТТЗ	126	6,002.1	34	2699.6	21	99.3	19	1640.4	52	1562.8
3	ОНӨААН	21	3932.3	5	3070.1	3	9.4	2	268.8	11	584
		170	13535.4	48	7816.9	29	136.3	30	3435.4	63	2146.8

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 13,535.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 7,816.9 сая төгрөгийн 48 алдааг залруулж, 136.3 сая төгрөгийн зөрчилд 29 төлбөрийн акт тогтоож, 3,435.4 сая төгрөгийн зөрчилд 30 албан шаардлага, 2,146.8 сая төгрөгийн алдаа, зөрчилд 63 зөвлөмж өглөө.

³ барилга байгууламжийн хувьд Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан зураг төсөл болон сүүлийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн магадлалаар баталгаажсан төсөвтэй байх;

5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Аудитаар нийт 14,371.8 сая төгрөгийн алдаа⁴ илэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-т "Аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх" заалтын дагуу санхүүгийн тайланд залрууллаа. Үүнд:

- Дуут сумын ТТЗ-ийн санхүүгийн тайланд ЗДТГазрын газар эзэмших эрхийг 86.8 сая төгрөгөөр үнэ төлбөргүй хандиваар гэсэн орлогын төрлийг зөрүүтэй бүртгэсэн нь санхүүгийн үр дүнгийн тайланд орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн нь УСНББОУС-17 холбогдох заалтыг мөрдөөгүй байна.
- Жаргалант сумын ТТЗ нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих байгууллагуудын санхүүгийн тайланг шилжүүлэхдээ өмчийн өөрчлөлтийн тайланд хаалтын тайлан хийхдээ нягтлан бодох бүртгэлийн бодлого өөрчлөлт дансанд тусгаагүй, өмнөх үеийн хуримтлагдсан дансыг 14,371.8 сая төгрөгөөр бууруулсан нь УСНББОУС-3, Сангийн яамны 2023 оны 01 дүгээр сарын 05-ний 10/84 тоот албан бичгээр Төсвийн тухай хуулийн дагуу 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргах чиглэлийн холбогдох заалтыг дагуу бүртгээгүй байна.

Аудитаар нийт 1,179.1 сая төгрөгийн зөрчил⁵ илэрснээс, 853.3 сая төгрөгийн албан шаардлага, 325.8 сая төгрөгийн 4 зөвлөмж хүргүүлээ.

5.1 Албан шаардлага:

5.1.1 Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Аймгийн Орон нутгийн өмчийн газраас хөрөнгийн бүртгэлд тавих хяналт сул, нэгтгэсэн хөрөнгийн мэдээ тайланг аудитын хугацаанд ирүүлээгүй, өмнөх онуудын аудитаар өгөгдсөн зөвлөмжөөр үндсэн хөрөнгийн бүртгэлд байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 0 үлдэгдэлтэй хөрөнгийг дахин үнэлж бүртгээгүй, Эмийн эргэлтийн сангийн 12.5, Үенч Эрчим хүч ТӨҮГ-ын 840.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө данс бүртгэлтэй ч бодитоор оршин байгаа эсэх нь тодорхойгүй, Мянган Угалзат ОНӨААТҮГ-ын Нэвт амралтын газарт 2022 оны 6 сард гал гарч 669 нэр төрлийн 426.8 сая төгрөгийн хөрөнгө шатаж аймгийн Прокурорын газар шийдвэрлэсэн, орон нутгийн өмчийн газар ИТХ-ын тогтоол шийдвэр гаргаагүй зэрэг зөрчил илэрлээ

Энэ нь ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолын 7.2-д "Эрх бүхий байгууллагын шийдвэрээр акталж, данснаас хасахаар шийдвэрлэж, зөвшөөрөл авсан боловч ашиглалтын шаардлага хангаж байгаа, дахин ашиглах боломжтой хөрөнгийн үнийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газартай зөвшилцөн тогтоож, дахин данс бүртгэлд тусгана", 7.3.5-д "ашиглах хугацааг сунгах, үнийг шинэчлэн тогтоох асуудлыг хэлэлцсэн өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлт", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3-д "Орон нутгийн өмчид хамаарах үндсэн хөрөнгийг бусдын өмчлөлд шилжүүлэх, барьцаалах, шинээр олж авах асуудлыг гагцхүү иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний хуралдааны чөлөөт цагт Хурлын дарга шийдвэрлэнэ" гэсэн заалтуудтай нийцээгүй байна.

5.2. Зөвлөмж

5.2.1 Үндсэн хөрөнгө данстай холбоотой асуудал:

⁴ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

⁵ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Илрүүлэлт: Аймгийн ЗДТГ-ын балансад бүртгэлтэй 40.0 сая төгрөгийн өртөгтэй ковшийг Шим ус ОНӨААТҮГ-т шилжүүлэхээр аймгийн ИТХ-ын даргын А/50 тоот захирамж гарсан аймгийн ЗДТГазар нь данс бүртгэлээс хасаагүй нь ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолын “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”, нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-т “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг нягтлан бодох бүртгэлд заавал тусгана” гэсэн заалттай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: А/50 тоот захирамжийн дагуу 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангаар данс бүртгэлээр хасаж залруулга хийж, хөрөнгийн бүртгэлийн давхардлыг арилгах

5.2.2 Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Булган, Үенч, Дуут, Мөст сумууд түүхт ойг тэмдэглэхдээ арилжааны банкинд хувь хүний нэрээр харилцах данс нээн орлого бүрдүүлэн зарцуулсан, хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй, бэлэн мөнгөний тайлан гаргаагүй нь Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ын 2.6-д “Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа (бусад орлого)-наас орох орлогыг мөнгөн кастаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг / түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй / ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана”, Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.1-д “төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж”, 47.2-д “Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна”, Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягт”, Засгийн газрын 2019 оны 204 тоот тогтоолын 2 дугаар хавсралтын 1.4-д “Байгууллагын тэгш ойг байгуулагдсан өдрөөс хойш 50 болон түүнээс дээш 10 жилийн давтамжтай тухайн салбарын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн болон аймаг, нийслэлийн Засаг даргын зөвшөөрлийг үндэслэн тухайн байгууллагын удирдлага холбогдох шийдвэр гаргаж тэмдэглэнэ” гэсэн заалтуудтай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Тайлант жилд ойн арга хэмжээ зохион байгуулах төсвийн захирагч нарын санхүүгийн үйл ажиллагааг удирдлага арга зүйгээр хангаж ажиллах аймаг, сумдын төрийн сангаас тавих дотоод хяналтыг сайжруулан ажиллаж, алдаа зөрчлийг давтан гаргахгүй ажиллах

5.2.3 Бусад өр төлбөртэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Ховд агро парк ХХК-ын газар тариалангийн үйл ажиллагаа явуулж буй газар нь 2016 оны 04 дүгээр сарын А/29 дугаар захирамжаар 15 жилийн хугацаатай эзэмшүүлэхээр захирамж гарч тухайн захирамжийг 2018 оны 09 дүгээр сарын 21 ны өдрийн А/106 тоот захирамжаар хүчингүй болгосон байхад тухайн газрын гэрчилгээгээр ХААДС-аас барьцаалбар үүсгэн 935.9 сая төгрөгийн үнэ бүхий усалгааны системийн тоног төхөөрөмжийг урьдчилгаа төлбөргүй жилийн 6 хувийн хүүтэй гэрээ байгуулан зээл авсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, Өрийн удирдлагын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1-д “өрийн удирдлагын хууль тогтоомжийн биелэлтийг хангах, хяналт тавих” гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

Өгсөн зөвлөмж : Өрийн удирдлагын тухай хуульд заасны дагуу өр төлбөрийг хэрхэн барагдуулж ажиллах талаарх эдийн засгийн тооцоо судалгаа, орлогын эх үүсвэрт хяналт хэрэгжүүлэн ажиллах

5.2.4 Татан буугдсан орон нутгийн өмчит газруудын бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Эмийн эргэлтийн сангийн 58.5 сая, Чандмань БИТ 9.3, Үенч эрчим хүч ТӨҮГ-ын 17.3 сая төгрөг өр төлбөр, Эмийн эргэлтийн сангийн 99.2, Үенч Эрчим хүч ТӨҮГ-ын 0.7 сая төгрөгийн бараа материал бодитоор оршин байхгүй, Чандмань БИТ, Эмийн

Ховд аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

эргэлтийн сан, Үенч Эрчим хүч ТӨҮГ-ын найдваргүй авлага бүртгэлтэй он удаан жил бүртгэгдсээр байна.

Өгсөн зөвлөмж : Аймгийн нэгтгэсэн санхүүгийн тайланд авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн дансанд олон жил үлдээгдлээр бүртгэгдсэн, бодитоор оршин байхгүй, хөөн хэлэлцэх хугацаа дууссан үлдээгдэлд Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, хууль тогтоомжийн дагуу шийдвэр гаргаж залруулах

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	
					Тоо	Дүн
Жаргалант сумын ТТЗ нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих байгууллагуудын санхүүгийн тайланг шилжүүлэхдээ өмчийн өөрчлөлтийн тайланд хаалтын тайланд нягтлан бодох бүртгэлийн бодлого өөрчлөлт дансанд тусгаагүй, өмнөх үеийн хуримтлагдсан дансыг бууруулсан	1	14,371.8	1	14,371.8	1	14,371.8
Дуут сумын ЗДТГазар газар эзэмших эрхийн биет хөрөнгийг үнэ төлбөргүй хандиваар бүртгэсэн,	1	86.9	1	86.9	1	86.9
Дүн	2	14,458.7	2	14,458.7	2	14,458.7

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Үүнээс					
	Нийт алдаа		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Булган, Үенч, Дуут, Мөст сумд түүхт ойг тэмдэглэн өнгөрүүлэх зорилгоор хувь хүний нэрээр арилжааны банкинд данс нээн орлого бүрдүүлэн мөнгөн хөрөнгийг бүрдүүлж, төрийн сангийн хяналтгүйгээр зарцуулсан	1	-			1	
Эмийн эргэлтийн сангийн 58.5 сая, Чандмань БИТ 9.3, Үенч эрчим хүч ТӨҮГ-ын 17.3 сая төгрөг өр төлбөр, Эмийн эргэлтийн сангийн 99.2, Үенч Эрчим хүч ТӨҮГ-ын 0.7 сая төгрөгийн бараа материал бодитоор оршин байхгүй, Чандмань БИТ -6.3, Эмийн эргэлтийн сан 25.6, Үенч Эрчим хүч ТӨҮГ	1	237.2			1	237.2

Ховд аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

10.3 сая төгрөгийн найдваргүй авлага он дамжин ТЕЗ-ийн тайланд бүртгэлтэй байна						
Ховд агро парк ХХК-ын ХААДС-аас барьцаалбар үүсгэн усалгааны системийн тоног төхөөрөмжийг урьдчилгаа төлбөргүй жилийн 6 хувийн хүүтэй гэрээ байгуулан зээл авсан	1	-			1	
Аймгийн ЗДТГ нь ИТХ-ын А/50 тоот захирамжаар балансаас балансад шилжүүлсэн ковш тээврийн хэрэгслийг санхүүгийн тайланд үндсэн хөрөнгөөс хасаагүй, Манхан сумын ЗДТГ орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн авто зогсоолыг данс бүртгэлд тусгаагүй,	1	88.6			1	88.6
Аймгийн Орон нутгийн өмчийн газраас хөрөнгийн бүртгэлд тавих хяналт сул, нэгтгэсэн хөрөнгийн мэдээ тайланг аудитын хугацаанд ирүүлээгүй, өмнөх онуудын аудитаар үндсэн хөрөнгийн бүртгэлд байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 0 үлдэгдэлтэй хөрөнгийг дахин үнэлж бүртгээгүй, Эмийн эргэлтийн сан, Үенч Эрчим хүч ТӨҮГ-ын үндсэн хөрөнгө данс бүртгэлтэй ч бодитоор оршин байгаа эсэх нь тодорхойгүй, Мянган Угалзат ОНӨААТҮГ-ын Нэвт амралтын газарт 2022 оны 6 сард гал гарч 669 нэр төрлийн хөрөнгө шатаж аймгийн Прокурорын газар шийдвэрлэсэн, орон нутгийн өмчийн газар ИТХ-ын тогтоол шийдвэр гаргаагүй	1	853.30	1	853.3		
Нийт дүн	5	1,179.1	1	853.3	4	325.8

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР